

Батлав: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны  
бодлого зохицуулалтын газрын дарга

/ Г.Энхмөнх /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүтээсэн:

"Моноцемент Билдинг Материалс" ХХК-  
ийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал.



/ Ц.Халиун /

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН  
НУТАГТ ОРШИХ "СЭНЖИТ ХУДАГ"  
ШОХОЙН ЧУЛУУ, ЦАХИУРЛАГ ЗАНАРЫНН  
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ЦЕМЕНТ  
ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВНӨӨРЛИЙН ДУГААР: МУ-013681  
ААН-НИЙН РЕГИСТРИЙН ДУГААР : МОНОЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС ХХК- 5106567

Хянасан:

БОАЖЯ-ны ХБӨБЗГ-ын мэргэжилтэн

/ /

Боловсруулсан:

Байгаль орчны мэргэжилтэн

/Т.Огиев/

Байгаль орчны мэргэжилтэн

/Г.Моңхтуул/

Улаанбаатар хот

2024 он

## Гарчиг

1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл.....	4
Төслийн талбай орших газрын засаг, захиргааны харьяалал .....	4
Дэд бүтэц, зам харилцаа.....	4
Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал.....	5
Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааны тухай мэдээлэл .....	6
<b>2. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ.....</b>	<b>8</b>
<b>3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>9</b>
3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах .....	9
3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	9
3.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах .....	10
3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах.....	10
3.5 Шимт хөрс хуулалт хадгалалт.....	11
<b>4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>21</b>
<b>5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>24</b>
<b>6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>27</b>
<b>7.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>27</b>
<b>8.ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>29</b>
<b>9.ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>32</b>
<b>10.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>36</b>
<b>11.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....</b>	<b>40</b>
<b>12.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>45</b>
<b>13. БОМТ-ӨӨГ СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ .....</b>	<b>47</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....</b>	<b>48</b>
<b>ХАВСРАЛТУУД .....</b>	<b>49</b>

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

<b>Төслийн нэр:</b>	Сэнжит худаг шохойн чулуун ордыг ил аргаар ашиглах төсөл
<b>Төслийн хүчин чадал:</b>	Жилд 1.3 сая тонн шохойн чулуу олборлох хүчин чадалтай
<b>Байршил:</b>	Дорноговь аймаг Өргөн сум
<b>Хаяг:</b>	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Автозамчдын гудамж, Монполимет Комплекс.
<b>Хариуцах хүн:</b>	Байгаль орчны мэргэжилтэн Т.Октябрь. <b>Утас:</b> 99045481
<b>БОННУ хийсэн</b>	“Өндөрхаан трейд” ХХК
<b>ААН-ийн нэр</b>	
<b>Батлуулсан огноо:</b>	2021 он

*Хүснэгт 1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол*

<b>СЭНЖИТ ХУДГИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ УУРХАЙН 2024 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>		
	<b>Түүхий эд</b>	<b>Нийт</b>
<b>Уурхайгаас олборлох түүхий эд</b>	Нийт шохойн чулуу, Эзэлхүүн мян.м3	<b>445.1</b>
	Шимт хөрс Талбай /га/ Эзэлхүүн / мян.м3/	<b>0.5</b> <b>1575</b>
	<b>Нийт уулын цул /мян.м3/</b>	<b>520.27</b>

## 1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл

“Сэнжит худаг” -ийн шохойн чулууны ордын тусгай 13681А тусгай зөвшөөрөл эзэмшигч “МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС” ХХК нь “Монполимет” группын охин компани бөгөөд 2012 онд Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших “Сэнжит худаг”-ийн шохойн чулууны ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж ордын бодитой (В) зэргийн бүх нөөцийг нийт 123.1 сая.тн шохойн чулуу байна гэж Монгол Улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөр батлуулсан. Энэхүү төслөөр ашиглалтын эхний 20 жилийн хугацаанд 1.9 сая.м<sup>3</sup> хөрс хуулж, 24.8 сая.тн шохойн чулуу олборлоно.

## 1.2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

### Төслийн талбай орших газрын засаг, захиргааны харьяалал

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 500 орчим км, Дорноговь аймгийн төвөөс 60 км, Өргөн сумын төвөөс зүүн тийш 3 км-т байрлана. Улаанбаатар Замын-Үүдийн төв магистрал төмөр зам, авто замаас зүүн тийш шороон замаар холбогдсон.


### Хүснэгт 2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

Талбайн дугаар, хэмжээ (га)	Булангийн цэгийн дугаар	Солбилцолууд	
		Х	Ү
MV-13681 458.44 га	1	110° 48' 15''	44° 44' 10''
	2	110° 49' 50''	44° 44' 10''
	3	110° 49' 50''	44° 42' 55''
	4	110° 48' 15''	44° 42' 55''

### Дэд бүтэц, зам харилцаа

Хүн амын байршил сийрэг 1 ам.км талбайд 0.4 хүн оногдоно. Нутгийн оршин суугчид нь халхчууд байх бөгөөд олонхи нь мал аж ахуй эрхлэж нүүдлийн соёл иргэншлэлээр амьдардаг. Сумын төвд оршин суугчид нь уул-уурхайн жижиг үйлдвэрүүд, төмөр замын өртөө болон орон нутгын захиргаа, үйлчилгээний нэгдэл, соёл үйлчилгээний байгууллагуудад ажилладаг.

Төслийн талбай нь ой мод байхгүй учраас барилгын болон бусад өргөн хэрэглээний модон материалыг эх орны хойд хэсгээс эсвэл хятад улсаас төмөр замаар тээвэрлэн авчирдаг. Үйлдвэрийн ба ахуйн хэрэглээний нүүрсийг Налайх, Таван толгой, Багануурын уурхайгаас татаж ашиглана. Өргөн сумын төвөөс баруун тийш 53 км зайтай Түшлэгийн, 38 км зайтай Хамарын хурлын нүүрсний ордууд байдаг боловч одоогоор ашиглагдаагүй байна. Сумын төв, хайлуур жоншны уурхай, төмөр замын 43-р зөрлөг нь Сайншанд хотоос 380 вольтын өндөр хүчдэлийн шугамаар цахилгаан эрчим хүчээр хангагддаг.



Зураг 1. Төсөл хэрэгжиж буй орчны тойм

### Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал

Төслийн талбай нь хойноосоо урагшаа намссан ухаа гүвээ гадаргатай. Аман-Ус, Сөгдөх, Хатуугийн төгрөг зэрэг газруудаар нам, жижиг бэсрэг уулс, дов толгодорхог гадаргуутай, говь хээрийн бүсэд хамаарагдана.

Газрын гадаргын үнэмлэхүй өндөр далайн түвшинээс дээш 960-1080 м-ийн хооронд хэлбэлзэнэ. Газрын гадаргын онцлог хэсэг нь ихэвчлэн мөлгөрдүү оройтой, налуу хажуутай, мезо-кайнозойн тунамал-терриген хурдас тархсан хөндий, ухаа гүвээт талархаг гадаргуу голлох ба хөндийн харьцангуй өндөржилт нь 10-30 м-т хэлбэлзэнэ.

**Ус зүй:** Судалгаанд хамрагдсан талбайд Баруун төгрөгийн уулан дахь 0.1 л/сек ундарга бүхий Улаан булаг-аас өөр байнгын ба түр зуурын урсгалтай гол горхи байхгүй. Харин ихэнхдээ сул давсархаг устай хэд хэдэн худаг байдаг. Ундны усны гол эх булаг нь Өргөн сумаас зүүн хойш 3 км-д оршдог 3.3 л/сек ундаргатай Дэрсэн усны худаг юм.

**Цаг Уурын байдал:** Судалгаа явуулсан нутаг нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай бөгөөд хоногийн болон сар, жилийн дундаж температурын хэлбэлзлэл ихтэй, хур тундас бага унадаг. Хүйтний эрч 12, 1, 2-р сард чангарна.

Хамгийн хүйтэн нь 1-р сард ба олон жилийн дундаж температур  $-19.1^{\circ}\text{C}$ -д хүрнэ. Хамгийн дулаан 7-р сард болдог ба олон жилийн дундаж температур  $+21.1^{\circ}\text{C}$ -д хүрнэ. Жилийн тундасны дундаж хэмжээ 113 мм-т хүрэх бөгөөд түүний 90 хувь нь V-IX сард, үүнээс VI-VII саруудад илүү ихээр унадаг. Анхны цас 11-р сарын эхээр унаж 4-р сарын эхээр хайлж дуусдаг. Өвлийн улиралд хөрсний хөлдөлтийн гүн 1.6- 2.4м хүрэх ба 6-р сард бүрэн гэсдэг.

**Ургамал зүй:** Судалгаанд хамрагдсан нутаг дэвсгэр нь тачир сийрэг ургамалтай, өнгөн хөрсний үеийн зузаан 0.05-0.5м.

Тал хөндий, энгэр ээвэр бэл газраар таана, хөмүүл, агь, толгодын оройн хэсэг хажуугаар хялгана, хазаар өвс, монгол өвс голлож ургана. Бутлаг ургамлаас бударгана, шаваг, алтан харгана тархмал ургана. Хөндийн хуурай сайруудыг дагаж ганц нэг хайлаас ургасан тохиолдоно.

**Амьтан судлал:** Төв Азийн говь цөлийн бүсийн араатан амьтан, өвсөн тэжээлтэн, мэргэчид, шавьж, хэвлээр явагчид, жигүүртэн зэрэг амьтад амьдардаг. Үүний дотор араатан амьтаны бүлгээс үнэг, хярс, хааяа чоно, өвсөн тэжээлтнээс туулай, хар сүүлт, цагаан зээр, уулархаг газраар цөөн тооны аргал, угалз, мэргэчидээс төрөл бүрийн хулгана, алаг даахай, хэвлээр явагчидаас могой, янз бүрийн гүрвэлүүд, жигүүртнээс сар, талын бүргэд, харцага, болжмор, ногтруу, шаазгай, хэрээ болон олон төрлийн шавьжууд дайралдана.

### **Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагааны тухай мэдээлэл**

Ордын нийт бодитой болон боломжтой /В+С/ зэргийн нөөцийг 249.40 сая.тн-оор АМГ-ын даргын 2012 оны 08 сарын 27-ны 494-р тушаалын дагуу Ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлжээ.

Ордын нийт бодитой /В/ зэргийн нөөцийг ил аргаар 1.3 сая.тн/жил-н хүчин чадлаар ашиглахад орд ашиглалтын хугацаа 90.4 жил гарах ба 2019 онд Гложекс ХХК-ниар орд ашиглалтын эхний 20 жилийн олборлолт, үйлдвэрлэлийн төлөвлөгөө, дэд бүтцийн шийдэл, эдийн засгийн тооцоололлыг тусгасан ТЭЗҮ хийгдсэн.

Ил уурхайн жилийн хүчин чадал 1.3 сая.тн байна. Төслийн хугацаанд нийт 24.59 сая.тн шохойн чулуу олборлож, 1.9 сая.м<sup>3</sup> хөрс хуулна.

“Монцемент Билдинг Материалс” ХХК нь Сэнжит худгийн шохойн чулууны ордыг түшиглэн жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх “Монцемент” төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Цементийн үйлдвэрийн эхний цементийн шугам 2015 оны 08 сарын 13-нд ашиглалтанд орж ажиллаж эхэлсэн.

### ***Техник, тоног төхөөрөмж***

Тус уурхайд өрөмдлөгийн ажилд 102-300 мм диаметр бүхий өрмийн хошуутай Ханжин /Hanjin/ фирмийн P7000 загварын 490 кВт-ын хөдөлгүүрийн чадалтай өрмийн машин, хөрс хуулалтын ажилд 1.3 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай САТ фирмийн 330GC загварын экскаватор, шохойн чулуу олборлолтонд 5.0 м<sup>3</sup> утгууртай ОХУ-ын ЭКГ-5А загварын шууд утгуурт цахилгаан экскаватор, хөрс тээвэрлэлтийн ажилд 60 тн даацтай Tonly- TL875 загварын автосамосвал, шохойн чулуу тээвэрлэх ажилд 30 тн даацтай SHACMAN-F3000 загварын автосамосвал, хөрсний овоолгод асгац түрэх, тэсэлгээгээр үүсэх нурлын хормой шуух, зам талбай тэгшлэх ажилд Комацу 155А бульдозар ажиллана. Ил уурхайн туслах ажилд зам тэгшилж засах автогрейдер, зам усалгааны, түлш цэнэглэгч зэрэг автомашинууд зэрэг нийт үйлдвэрлэлийн 10 ш техник, тоног төхөөрөмж ажиллана.

### ***Ил уурхайн ашиглалтын систем***

Гадаад овоолготой автотээвэртэй ашиглалтын системээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хөрс хуулалтын ажил хийхээс өмнө шимт хөрсийг 0.2-0.4 метрийн зузаантайгаар Комацу-155А бульдозероор түрж овоолох ба САТ-330 экскаватороор SHACMAN-F3000 автосамосвалуудын хослолоор ачиж шимт хөрсний овоолгод буулгана.

Хөрс хуулахад САТ-330 экскаватор -1 ш, SHACMAN-F3000- 2ш маркын автосамосвалаар, шохойн чулуу олборлоход ЭКГ5А- 1ш маркын экскаватор, Tonly- TL875 автосамосвал - 2 ш, SHACMAN-F3000 маркын автосамосвал -1 ш хослуулан ашиглахаар төлөвлөж байна.

Ашиглалтын явцад ажлын талбай засах, овоолго тэгшлэх болон зам засах ажилд Комацу-155А маркын бульдозер, SEM-919 маркын автогрейдер ашиглана. Ачилт хийх үед “ХАБЭА хууль, ХАБЭА менежментийн систем, холбогдох журам зааварыг чанд баримтлан

зөвхөн тэвшин талаас нь ачилт хийж гүйцэтгэнэ. Автосамосвалд ачиж дуусмагц экскаваторын машинч, оператор сигналаар дохио өгөх мөн давхар радио станцаар тодорхой хэлж ачилт дууссаныг мэдэгдэнэ. Автосамосвалд хөрс болон хүдэр ачих үед ачааны тогтвортой байдлыг сайтар хангаж ачилтыг хийж гүйцэтгэнэ. Ачаатай машин нь овоолгын талбайд очсоны дараа тогтоосон байрлал, өндөржилтийн дагуу асгалт хийнэ.

Овоолгын захад буулгалт хийж байгаа авто машиныг доош гулсаж унахаас сэргийлэн овоолгын талбайн захаар 1 м хүртэл өндөртэй хамгаалалтын далан үлдээж бульдозероор түрэлт хийнэ.

### **Ил уурхайн өрөмдлөг**

“Сэнжит худаг” ил уурхайн шохойн чулууны өрөмдлөгийн ажилд мөн шаардлага гарсан үед цахиурлаг занар, хөрсний өрөмдлөгт 2020 онд ашиглалтанд орсон СБШ-250 цахилгаан өрмийн машин ажиллахаар төлөвлөсөн

### ***Ил уурхайн тэсэлгээ***

Шохойн чулуу, цахиурлаг занарын уурхайн тэсэлгээний ажилд энгийн тэсрэх бодис анфо хэрэглэнэ. Тэсэлгээний ажлын тооцоог бутлагдлын дундаж хэмжээг хангах болон ил уурхайн тэсэлгээ хийх доголын өндрийн нөхцөлөөр тус тус харгалзан тооцсон доорх аргачлалаар тооцсон ба уурхайд ашиглах СБШ-250 цахилгаан өрмийн машины өрөмдөх цооногийн диаметр 250мм байна. Тус уурхайд өрөмдлөг тэсэлгээ хийж хөрс хуулалт болон олборлолтын ажил явагддаг.

## 2. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн БОНБНУ тайлан болон тус тайланд тусгасан ОХШХ-г үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн БОАЖЯ-ны сайдын А-618 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болгов. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлзэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх болно.

“Монцемент билдинг материалс” ХХК -ийн “Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэхэд 49’587’000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна.

*Хүснэгт 3. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал*

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төсөв /мян.т/	Тайлбар
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11150.0	
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	7200.0	
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21400.0	
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	ҮА хэрэгжүүлэхгүй.
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	200.0	
6.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1750.0	
7.	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1950.0	
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1650.0	
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3087.0	
10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	700.0	
11.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	500.0	
<b>2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв</b>		<b>49587.0</b>	



### **3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдлоо. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авна.

#### **3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Төслийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд ашиглах машин механизмуудын утаат яндангаас ялгарах хорт хийн агууламжийг бууруулах зорилгоор утааны янданг тусгай шүүлтүүрээр тоноглохын зэрэгцээ техникийн оношлогоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Мөн уурхайн задгай талбайд олборлолтын үйл ажиллагаагаар ялгарах тоосны хэмжээг бууруулахын тулд задгай талбайг усалж, чийгтэй байлгах арга хэмжээ авах, аль болох богино хугацаанд нөхөн сэргээлт хийх

- Уурхайн үйл ажиллагаанаас агаарт тархах тоосны хэмжээг багасгах, салхиар дамжин хотын суурьшлын бүсрүү тархахаас сэргийлж уурхайн эргэн тойронд ногоон байгууламж барих

- Уурхайн шимт хөрсний болон гадаад овоолгын талбайг хуурай, салхи ихтэй, агаар мандал тогтворгүй үед усалж байх хэрэгтэй.

#### **3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Шохойн чулуу олборлох уурхайн төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн явцад хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх.

- Уурхайгаас гарах шороог төслийн дагуу овоолгын талбайд зөв байрлуулан асгаж, дагтаршуулах, хур тунадас, салхины нөлөөгөөр үүсэх хагарал, хотойлт зэргийн шалтгааныг судалж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай.

- Бүтээгдэхүүн тээвэрлэх машины зөөвөрлөх талбайд орох, гарах маршрутыг нарийвчлан тогтоох, олон салаа зам гаргахгүй байх, машин механизмын үзлэг үйлчилгээ хийх талбайг тогтоож, тэнд хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай.

- Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх

- Олборлолт дууссаны дараа уурхайд ашиглагдсан талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх
- Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг өтөг бууцаар бордож, олон наст ургамлын үр цацах, мод бут суулгах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх
- Уурхайн олборлолт, барилга байгууламж байгуулах явцад эвдэрсэн хөрсийг засч тэгшлэх, нөхөн сэргээх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх
- Хөрс хадгалах зориулалттай талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэл доорх нөхцлийг хамгийн бага байхаар төлөвлөх
- Шимт хөрсийг хамгаалахын тулд овоолгын өнгөн хэсгийг сэргээх, үүний тулд овоолгын гадаргуугийн хөрсөнд усалгаа хийх, тохиромжит ургамлын үр цацах, гадаргуугийн бүрхэвч бий болгох, хажуу бэлийг хамгаалах зорилгоор геоматериалаар хучих арга хэмжээ авах.

### **3.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

- Газрын доорх ус буюу ундны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах, тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна. Нөгөө талаар бороо хурын ус чийг, хөрсөнд бий болсон дээрх бохирдлуудыг цааш дамжихад ихээхэн нөлөөлөлтэй байдаг тул нэн түрүүн хөрсийг шатах, тослох материалаар бохирдохоос хамгаалах, бохирдсон нөхцөлд нэн даруй арга хэмжээ авч байх шаардлагатай.
- Өөрийн ашиглалтын талбай дахь болон эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдтэй хамтран ажиллах.
- Ажилчид болон төслийн талбай түүний нөлөөллийн бүсэд байх талбай дахь ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэх эсэхэд байнга хяналт тавьж ажиллана.

### **3.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Төслийн явцад ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ашиглалтын талбайн ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх, маршрутын зам гаргах
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хогийн нэгдсэн цэг байгуулах, хогийг орчиндоо тархахааргүй байх талаар арга хэмжээ авах.
- Уурхайн ашиглалтын явцтай зэрэгцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын хийх,
- Ногоон байгууламж барих,
- Биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах ургамлыг сонгож, тарималжуулах

### **3.5 Шимт хөрс хуулалт хадгалалт**

Төсөл нь байгалийн бүс бүслүүрийн ангилалаар говь цөлийн бүсэд хамаарах бөгөөд уг бүслүүрт говийн бор, говийн цайвар бор, цөлийн бор саарал, борзон хөрс зонхилон тархдаг бөгөөд шимт хөрсийг тухай бүс бүслүүрийн онцлогоос хамааруулан 20 см-ээр MNS 5916:2008 стандарт шаардлагын дагуу хуулж хадгалахаар төлөвлөв.

Үржил шимт хөрсний овоолгыг үүсгэх болон хадгалахад дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Үржил шимт хөрс хуулалтыг стандартын дагуу хийх технологийг ажилтан, машин механизмын жолооч нарт эзэмшүүлэнэ.

- Шимт хөрсний овоолгыг газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгална.

- Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлнэ. Тухайлбал үржил шимт хөрсний овоолгыг олон дахин зөөхгүйгээр тогтвортой хадгалах талбайд байршуулах ба уулын хажуу болон гуу жалгатай газар овоолгыг байршуулбал борооны болон үерийн усаар урсаж алдагдах тул ус зайлуулах суваг шуудуу татах, эсвэл усанд урсахааргүй газарт байршуулна.

- Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр, хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан байхаар хэлбэршүүлэх бөгөөд шимт хөрсний овоолгын өндрийг 5 метрээс илүүгүй байхаар үүсгэхэд 5.0 га талбайг эзэлж байгаа болно.

- Шимт хөрсийг салхины зонхилох чиглэлийн дагуу шимт хөрсний овоолгын гадна талаар салхиар тоос шороо дэгдэн, шимт хөрс алдагдахаас сэргийлж хашаа хамгаалалт хийж, овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлэн олон наст өвслөг ургамал тарьж хашаа хамгаалалт хийнэ.

- Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолгоо, бүртгэл, хяналтын ажлыг байнга хэрэгжүүлнэ

### **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө нь “Монцемент билдинг материалс” ХХК -ийн “Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө бөгөөд доорх хүснэгтэд тусгагдсан арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэн ажиллахаас гадна тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд нэг бүрчлэн тусгаж, биелэлтийн тайланд хэрэгжилтийн хэмжээ гүйцэтгэлийн талаар тодорхой тусгаж тайлагнаж байх шаардлагатай.

Тухайн төслөөс үүсэх гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлсны үндсэн дээр сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах талаар ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээг хугацаа болон зардал мөнгөтэй нь доорх хүснэгтээр үзүүллээ.

## СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
<b>1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>										
Салхи шуурга ихтэй үед ордын ашиглалтын талбайгаас тоос босч орчны агаарт бохирдол үүсгэнэ  Хөрсний чийг бага, салхины хурд их үед агаар дахь тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх үндэслэлтэй	<b>1.1.</b> Тоосжилт үүсэх зам, ажлын талбайнуудыг услах маршрут гаргах, чийгшүүлэх арга замыг нэмэгдүүлэх	Уурхайн дотоод, гадаад зам талбай	км	25-30 удаа	2000.0	2000.0	ЭХУХХ, ХАБЭАБОХ.	3-11 сар хүртэл өдөрт 2 удаа	-Агаарын тухай -Байгаль орчныг хамгаалах тухай -Ашигт малтмалын тухай хуулиуд -Агаарын чанарын MNS 4585:2016 стандарт	
	<b>1.2.</b> Тоосжилт үүсэхээс сэргийлж хурдны хязгаарлалтыг мөрдөн ажиллах, хүчтэй салхи шуургатай үед ажлыг түр зогсоох.	Уурхай болон үйлдвэрийн бүсэд	-			ҮАЗ-д тусгасан	ҮАЗ-д тусгасан	ХАБ-ын мэргэжилтэн		Жилийн турш
	<b>1.3.</b> Үйлдвэрийн тоос барих төхөөрөмжийн ханцуй 6500ш солих. тоосжилт бууруулах ажлууд үргэлжүүлэн хийгдэх, Чулуунцар вагонд ачихын хошууг сольно. Түүнд хяналт тавьж ажиллана.	Үйлдвэрийн бүсэд.	-	Тогт мол		ҮАЗ-д тусгасан	ҮАЗ-д тусгасан	ЭХУХХ, ХАБЭАБОХ.		Жилийн турш
Шохойн чулуу болон хаягдал чулуулаг, шимт хөрс тээвэрлэх үед хүнд даацын машин механикийн хөдөлгөөнөөр сул шороо үүсэж, тоосжилт ихсэж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	<b>1.4</b> Тээвэрлэлт хийх шороон замд тээврийн жолооч нарт хурдны хязгаарлалтанд хяналт тавих /хурд хяналтын багаж 1ш авах. Хурдны хязгаарлалт заасан тэмдэг 5ш хийх/	Уурхай болон үйлдвэрийн бүсэд	Тогт мол	-		Шаардлагагүй.	ХАБ-ын мэргэжилтэн	Тогтмол	Байгаль орчны нөлөөллийн арга үнэлгээний дагуу. Хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм, журам	
Уурхай болон үйлдвэрийн ажил болон машин механизмын хөдөлгөөний улмаас хүрээлэн буй орчин дахь	<b>1.5</b> Ажлын байранд чихний бөглөөс болон хамгаалалтын чихэвч байнга хэрэглэж байх	Төслийн талбай болон үйлдвэрийн гадаад болон	-	-		Үйл ажиллагааны зардалд тусгах	ХАБ-ын мэргэжилтэн	Төслийн хугацаанд	MNS 4599:2003	

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
шуугианы бохирдлын түвшинг ихсэж физик нөлөөлөл үүснэ.		дотоод орчинд							
<b>Зардал</b>						<b>2000.0</b>			
<b>2. Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>									
Хөрс хуулалт хийх, зам талбай гаргах, төслийн талбайн үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах	<b>2.1.</b> Уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэх буй талбайн шимт хөрсийг тухайн газрын гадаргын хэв шинжийн онцлогоос хамааран 20-40 см орчим зузаан хуулж, овоолго үүсгэн хэлбэржүүлж хадгалах	Нийт төслийн хэмжээнд	га	0.5	Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	БО мэргэжилтнүүд	Төслийн нийт хугацаанд	MNS4919-2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”, MNS4920-2000 “Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага”	
Хүнд, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй Төслийн талбайн хөрс, газрын гадарга олон машин техникийн нөлөөгөөр талхлагдах, олон салаа зам үүсэх сөрөг нөлөөлөлтэй.	<b>2.2.</b> Төлөвлөлтөөс гадуурх талбайд нүх ухах, зам талбай үүсгэх зэргээр хөрсний элэгдэл эвдрэлд орохоос сэргийлж, инженер техникийн ажилчдад анхааруулж байх, түүнд хяналт тавих.	Үйлдвэрийн ба уурхайн бүсэд	-		-	Хэлтэс нэгжүүд	Тухай бүрд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд	
Бензин, тос, дизель (шатах тослох материал) зэргийн асгаралт, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүсэх.	<b>2.3.</b> Засварын газар, ШТС зэрэгт тос, масло асгарсан тохиолдолд асгарсан бохирсон хөрсийг тухайн үед нь цэвэрлэх /асгарсан үед авах журам шинэчлэн боловсруулах/ Асгарсан тос, маслоор	Төслийн талбай болон үйлдвэрийн гадаад болон дотоод орчинд	-		2000.0	ХАБЭАБОХ	Тухай бүрд	Байгаль хамгаалал, Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх стандарт MNS 3297:2019	

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	бохирдсон хөрсийг хадгалах, саармагжуулах цэг хийх.								
	<b>2.4.</b> Батлагдсан зураг төслийн дагуу тос, масло хадгалах агуулах барих.	Үйлдвэрийн ба уурхайн бүсэд	м <sup>2</sup>		300.0		ЗМХ, ХАБЭАБОХ	5, 6 сард	Газрын тухай, Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль-уудаас заалтыг авах
	<b>2.5</b> Уурхайн авто граш болон бетон хучилттай автомашины шинэ зогсоол ашиглалтанд оруулах.	Үйлдвэрийн ба уурхайн бүсэд	-	-	ҮАЗ		ЗМХ, ХАБЭАБОХ	2024	Байгаль хамгаалал, Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх стандарт MNS 3297:2019
<b>Зардал</b>					<b>3500.0</b>				
<b>3. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>									
Усны сан бүхий газар, түүний онцгой хамгаалалтын бүс, унд ахуйн худгийн эрүүл ахуйн бүс хог хаягдлаар бохирдох, уурхайн үйл ажиллагаанд өртөх.	<b>3.1.</b> Усны хэрэглээндээ хяналт тавьж, улирал бүрийн мэдээг гарган орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагчид хүргүүлж байх	Үйлдвэр болон уурхайн хэмжээнд	-	-	Усны хэрэглээг хянах ашиглалтын дүгнэлт гаргуулахад Жилд 500.0		Химич, усны болон БО мэргэжилтнүүд	Жил бүр	MNS0900:2018-Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ;
Газрын доорх усыг авч ашигласнаар газрын доорх урсцын горим алдагдах, нөөц багасах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй.	<b>3.2.</b> Усан хангамжийн худгууд дээр усны түвшиний хэмжилт, усны чанарын шинжилгээг хийх, хаягдал усанд усны чанарын шинжилгээ, хийлгэх <b>3.3.</b> Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаар гаргуулж ажиллах	Үйлдвэр болон уурхайн хэмжээнд	-	-	Засвар сервис үйлчилгээний зардалд тусгагдсан.		Химич, усны болон БО мэргэжилтнүүд	Жил бүр	MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ; MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага; MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх;

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Усан орчин хамгаалалт	3.4 Эрүүл ахуйн бүс тогтоосон HS3, Баргилт, Хайлааст гүний худгуудын хашааг эвдэрсэн үед нь засвар хийлгэх. Худгуудын хаягжуулалтыг шинээр хийх.	Үйлдвэр болон уурхайн хэмжээнд	-	-	2000.0		ЭХУХХ	6-8 сар	Усны тухай хууль
<b>Зардал</b>					2500.0				
<b>4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>									
Газар шорооны ажил болон машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан нөмрөгт нөлөөлөл үзүүлнэ. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	4.1. Өмнө жилүүдэд суулгасан модны суулгацын усалгаа, арчилгааг улиралын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Нийт төслийн хэмжээнд	Мод ш	600 ш	5.0	2,500.0	БО мэргэжилтэн	Төслийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллах	Монгол улсын стандарт MNS:5973:2009 буюу “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ”-г тогтоосон стандарт
	4.2 Үрийн нөөц бүрдүүлэх: Буйлс, Жигд модны үр түүж бэлтгэх.	Үйлдвэр болон уурхайн хэмжээнд				Шаардлагагүй	БО хэсэг	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль.
Орон нутаг	4.3 Нутгийн ургамлын үрийн нөөц бий болгох, орон нутаг сургуулийн хүүхдүүд болон сумын эко клуб сайн дурын ажилчид нөхөрлөл зэрэгтэй хамтран ажиллаж, нутгийн ургамлын үр цуглуулах болзолт уралдаан зарлах, намар харгана болон бусад сөөг сөөгөнцөр ургамлын үр цуглуулах болзолт уралдаан зохион байгуулж, нутгийн үрийн фонд бий болгож стандартын дагуу хадгалах, мөн ховор ургамлын үр түүж	Үйлдвэр болон уурхайн орчимд	кг	6	ҮАЗ.д тусгагдсан.		БО мэргэжилтэн	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль.

**МОНЦЕМЕНТ ҮЙЛДВЭР “СЭНЖИТ ХУДАГ” ШОХОЙН ЧУЛУУ, ЦАХИУРЛАГ ЗАНАРЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ЦЕМЕНТ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	цуглуулах, нөхөн сэргээлтэнд ашиглах								
	4.4 Өргөн сумын ЕБС-ийн сурагчдад мод үржүүлгийн талбайг танилцуулах.	Үйлдвэр, МҮГ			ҮАЗ.д тусгагдсан.		МБМ ХХК БОМ, Өргөн сум БОБтэн	2024 он	
<b>Зардал</b>						<b>2500.0</b>			
<b>5. Амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>									
Үйлдвэр, уурхайн том машин техникийн нөлөөгөөр зэрлэг ан амьтадын тоо толгой буурах, үргэж дайжах сөрөг нөлөөтэй.	5.1 Амьтдын тоо, толгой буурах, дайжих, амьдрах орчин устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалж орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран сургалт зохион байгуулах. Говийн ан амьтны талаарх сонирхолтой сургалтыг бэлтгэж, орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран сургалт зохион байгуулах.	Төслийн хүрээнд	Жил д	1	500.0	Сургалтанд 1 жилд 500.0	БО мэргэжилтэн болон сумын БО-ны байцаагч	2024 он	Амьтны тухай хууль болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга зөвлөмжийн дагуу.
Цахилгааны шугамууд дээр суусан махчин шувууд тогонд зохилж үхэх, тоо толгой цөөрөх нөлөөлөл үүсэж болзошгүй.	5.2 Агаарын шугамууд болон 110 кВ ил хувиарлах байгууламжын портал дээр шувуу үргээгч толь байршуулах -100ш.	Төслийн талбайн хэмжээнд	ш	100	8.5	850.0	БО мэргэжилтэн болон сумын БО-ны байцаагч	2024 он	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга зөвлөмжийн дагуу.
<b>Зардал</b>						<b>1250.0</b>			
<b>6. Оршин суугчид болон ажиллагсдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал</b>									
Үйлдвэрийн бутлалт, тээрэмдэлт, шатаах системийн хэсэгт ажиллах ажилчид тоосжилт, дуу чимээ	6.1. Ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах.	Төслийн уурхай болон үйлдвэрийн ажилчид	Хүн	230	-	ХАБЭ А зардалд тусгагдсан.	Монцемент билдинг материалс” ХХК	Жил бүр	Хөдөлмөрийн тухай хууль MNS4968:2000. ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл



**МОНЦЕМЕНТ ҮЙЛДВЭР “СЭНЖИТ ХУДАГ” ШОХОЙН ЧУЛУУ, ЦАХИУРЛАГ ЗАНАРЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ, ЦЕМЕНТ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
ихтэй, температурын эрс өөрчлөлттэй ерөнхийдөө хүрээлэн буй орчны физик бохирдолттой хөдөлмөрийн хүндэвтэр нөхцөлд ажиллах тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөж болзошгүй юм.	6.2. Ажилтнуудын дунд тохиолдож буй өвчлөлийг тодорхойлох, улирал, цаг хугацаагаар судалгаа хийх								ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”
Зардал									
<b>Байгаль хамгаалах төлөвлөгөө 2024 онд</b>						<b>11150.0</b>			

“Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг 11 150 000 төгрөгөөр зарцуулахаар төлөвлөж байна.

## **ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцож буй Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Дэлхий нийтийн өмнө тулгараад буй уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахын тулд 2030 он гэхэд Монгол Улсад тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг зарласан бөгөөд энэхүү санаачлагын дэмжин Монполимет Групп 1 сая мод тарин ургуулах амлалтаа өгсөн.



*Зураг 2. Нэг тэр бум үндэсний хөдөлгөөнийг дэмжин амлалт өгч баталгаажуулах үйл ажиллагаа*

#### 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Монцемент билдинг материалс” ХХК-ийн “Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн олборлолтын үйл ажиллагааны улмаас өнөөгийн байдлаар 23.69га ухаш 2.8га хөрсний овоолго үүссэн байна.

Иймээс холбогдох журмын дагуу үржил шимт хөрсний овоолгыг “MNS 5916:2008 стандартын дагуу үүсгэж, газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу хадгалж хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. Мөн уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг хийхдээ MNS 5914:2008, MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008, MNS 4943:2011, MNS 6296:2011, MNS 900:2005, MNS 6148:2010, MNS 3597:1983 стандартуудыг баримтлан хийх шаардлагатай.

Шимт хөрсийг 2-оос илүү жилээр хадгалах шаардлага гарч байгаа тул салхины зонхилох чиглэлийн дагуу шимт хөрсний овоолгын гадна талаар салхиар тоос шороо дэгдэн, шимт хөрс алдагдахаас сэргийлж хашаа хамгаалалт хийж, овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлэн олон наст өвслөг ургамал тарьж хамгаалалт хийнэ.

Төслийн явцын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг доорх хүснэгтээр үзүүллээ.

**Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Д/д	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	Техникийн болон биологийн нөхөн сэргээлтэнд шаардагдах шимт хөрсийг стандартын дагуу хадгалах, хэлбэржүүлэлт хийх	Шимт хөрсийг хуулах 0.5 га талбай  Шимт хөрсийг хамгаалах, хадгалах;	1575 м <sup>3</sup>	Олборлолтын зардал тусгагдсан	Олборлолтын явцад	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн шаардлага. MNS5915:2008;  Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008;
2.	Уурхайгаас үйлдвэр хүрэх технологийн зам дагуу мод тарьж ой зурвас бий болгох	Зам дагуу 1.4 га талбай 100 ш мод тарилт хийж ургуулах	Технологийн зам дагуу	100 ш х 4.5=450.0	Жилийн турш	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага. MNS 5917-2008;
3.	Шимт хөрсийг 2-оос илүү жилээр хадгалах шаардлага гарч байгаа тул салхины зонхилох чиглэлийн дагуу шимт хөрсний овоолгын гадна талаар салхиар тоос шороо дэгдэн, шимт хөрс алдагдахаас сэргийлж хашаа хамгаалалт хийж, овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлэн олон наст өвслөг ургамал тарьж хамгаалалт хийнэ.	Шимт хөрс ургамалжуулах	Үйлдвэрийн талбай	400ш х 6.0=2400.0		Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2008;

4.	Үйлдвэрийн ногоон байгууламжийг сайжруулах	Моджуулах	Үйлдвэрийн талбай	315ш х 6.0=1890.0	Жилийн турш	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2008;
<b>Нийт төсөв</b>				<b>7200.0</b>		

“Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн 2024 онд нөхөн техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй бөгөөд харин шимт хөрс хуулах ажил хийгдэх болно. Иймд шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүй тоосжилт үүсгэхгүй байх үүднээс ургамалжуулан хадгалах бөгөөд уг ажилд 7 200 000 төгрөг зарцуулахаар төлөвлөв.

## 5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал болон амьдрах орчны нөхцөл илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын гол зорилго оршино.

*Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө*

Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж
Шанаган могойтын газар доорх усыг хамгаалах, Шувуун хөөврийн булгийг хашаажуулж хамгаалах.	Дорноговь аймгийн Өргөн сум Шувуун хөөврийн булаг	Сум орон нутгийн хэмжээнд	0.7га	21400.0	2024 он
Зэрлэг ан амьтад хамгаалах биотехникийн арга хэмжээ	Дорноговь аймаг Сайншанд, Өргөн, Эрдэнэ сум	км	740	-	2024 он
<b>Нийт дүн</b>				<b>21400.0</b>	



Зураг 3. Шувуун хөөврийн булаг



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН  
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

305 тоот, Соёмбо цогцолбор, 3 дугаар баг,  
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103  
Утас/факс: (976) 7052 3681,  
Цахим шуудан: Galba.usgz@gmail.com

2024.02.26 № 29  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УС АШИГЛАГЧ АЖ АХУЙН  
НЭГЖҮҮДЭД

Монгол Улсын хэмжээнд зудтай, сав газрын хэмжээнд өнгөрөгч онд зуншлага муу, цас их байгаа энэ үед хулан адуу, хар сүүлтий зээр, цагаан зээр, аргаль хонь зэрэг ан амьтдын идэш тэжээл хомс байгаагаас болж ан амьтад ихээр хорогдож байна.

Цаг үеийн ийм хүндрэлтэй үед Сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх хүрээнд ан амьтад био техникийн арга хэмжээ авах, өвс тэжээл бэлтгэх ажилд дэмжлэг үзүүлж та бүгдийг хамтран ажиллахыг хүсье.

ДАРГА

Б.ЯЛАЛТБАЯР

3420/0050

Зураг 4. Албан бичиг




## 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх малчин айл өрх байхгүй. Уурхай нь үйл ажиллагаа явуулж дууссаны дараа уурхайн хаалттай холбоотой нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ.

## 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Археологийн хайгуул, тандан судалгааны ажлын үр дүнд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн урд хэсэгт дугуй хэлбэрийн намхан дардастай, голдоо хонхор булш нэгийг илрүүлэн дурсгалын гадаад зохион байгуулалтад үндэслэн хүрэл, төмрийн түрүү үед холбогдох булш, оршуулгын дурсгал хэмээн урьдчилсан байдлаар үзэж баримтжуулсан бөгөөд олборлолтын талбайгаас урагш 2 км тэсрэх бодисын агуулахаас 700 м-ээс 1 км зайтай нөлөөлөлд өртөхөөргүй байна.

Зураг 1. Археологийн олдворын байршил



— Газар шорооны ажлын үед өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй. Иймд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн заасны дагуу түүхийн болоод соёлын өв сангийн зүйлүүд олдох

буюу байх магадлал ихтэй бол нэн даруй төслийн үйл ажиллагааг зогсоож, орон нутгийн засаг захиргаа мөн улс төрийн болон холбогдох шинжлэх ухааны судалгааны байгууллагуудад мэдэгдэх үүрэгтэй. Уг үүргээ хэрэгжүүлэн ажиллана.

— Түүх, соёлын дурсгал болон ард түмний зан үйлд харшлах зүйлсийг хөндөхгүй байхын үүднээс талбайд орших дурсгалт зүйлст хамгаалалт хийх, ойр орчмоор нь машин техник явуулахгүй байхаар зохион байгуулна.

**Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал Мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Соёлын өвийн талаарх сургалт, зааварчилгаа өгөх	Уурхайн ажилтнуудад	200.0	2024 он	Соёлын өвийн тухай хууль
Түүх соёлын дурсгалт газрыг тоногдон дээрэмдүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэмдэг тэмдэглэгээ хийх, ажиглалт хамгаалалтанд авах	Дурсгалт газар		2024 он	
Төслийн талбайд шинээр газар хөндөх үед соёлын өвд хамаарах эд өлгийн зүйл олдох үед холбогдох археологи, палентлого газарт мэдэгдэх	Газар шорооны ажил хийх талбайд зөвхөн илэрсэн тохиолдолд	Илэрсэн үед ашиглах гэнэтийн зардал учир жил бүрийн БОМТ-ын зардалд тусгаагүй болно.	2024 он	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
<b>Нийт зардал</b>		<b>200.0</b>		

## 8. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэсэлгээний ажил нь шохойн чулуу, цахиурлаг занаржсан аргиллит зэрэг чулуулагт хийх тул чулуулгийн физик-механик шинж чанарт тулгуурлан үзүүлэлтүүдийг сонгож тооцоолсон. Шохойн чулууны бат бөхийн коэффициент нь профессор М.М.Протодьяконовын ангиллаар III бүлэгт буюу хүнд тэслэгдэх зэрэгт орох ба эзлэхүүн жин дунджаар 2.59 тн/м байна

Тэсэлгээнд Анфо болон Эмульсийн тэсрэх бодисыг хэрэглэхээр тооцсон ба 20 жилийн хугацаанд 1.5 сая.м<sup>3</sup> уулын цулын материалд 1.1 тонн эмульсийн тэсрэх бодис хэрэглэхээр тооцсон байна.

Цементийн үйлдвэрийн технологийн дамжлагад химийн бодис ашиглахгүй бөгөөд лаборатори болон саарал ус цэвэршүүлэх системд химийн бодис ашиглана. Лаборатори болон саарал ус цэвэршүүлэхэд нийт 97 нэр төрлийн бодисыг жилд ойролцоогоор 221.6 кг хуурай, 192 л шингэн бодис хэрэглэхээр тооцсон байна. Химийн бодисын нэр томъёо, зарцуулалтын хэмжээг химийн эрсдэлийн үнэлгээнд нарийвчлан авч үзсэн.

**Хүснэгт 8. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал**

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Химийн Бодисын ашиглалт хамгаалалт	Лабораторийн ажилчдад бодис материалын шинж чанар, аюулгүй ажиллагааны зохих мэдэгдэхүүнийг олгож, заавар журам боловсруулж ажиллах. Агуулахад хадгалах бодис материалын “data sheet”-д тусгагдсан хадгалах нөхцөл болон бусад нөхцлийг баримтлах.	Лабораторийн химийн бодистой харьцаж ажиллаж байгаа бүх шатны ажилтан, албан хаагчид химийн бодистой харьцах заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах	Бүх бодисын хэмжээнд Төслийн хугацаанд	-		ҮАЗ-д тусгагдсан	Төслийн хугацаанд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	Химийн бодисын хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авах	ЧЛХ, ЭХУХХ		-		1950.0	Төслийн хугацаанд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	Шингэнийг алдагдуулахгүй байх зорилгоор савалгаатай материалын таг, лац ломбийг тогтмол шалгаж байх, шингэн агуулж буй савыг гэмтээхээс хамгаалах боломжит арга хэмжээг авах	Лабораторийн химийн бодистой харьцаж ажиллаж байгаа бүх шатны ажилтан, албан хаагчид химийн бодистой харьцах заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах		-		ҮАЗ-д тусгагдсан	Төслийн хугацаанд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	Химийн бодисын хяналт, саармагжуулалт, устгалыг зааврын дагуу гүйцэтгэх	Лабораторийн химийн бодистой харьцаж ажиллаж байгаа бүх шатны ажилтан, албан хаагчид химийн бодистой харьцах заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах		-		ҮАЗ-д тусгагдсан	Төслийн хугацаанд	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
Лаборатори болон ус цэвэршүүлэх байгууламжид	Химийн бодисын ашиглалтын тайлан	Лабораторийн химийн бодистой харьцаж ажиллаж байгаа бүх	Бүх бодисын хэмжээнд	Нэгж зардлаар бус нийт	97	ҮАЗ-д тусгагдсан	Төслийн хугацаанд	Химийн хорт болон аюултай

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
ашиглах 97 нэр төрлийн химийн бодисын хадгалалт, ашиглалтын стандарт, дүрэм журам мөрдөөгүйн улмаас эрсдэл үүсэх	холбогдох газруудад тогтсон хугацаанд хүргүүлж байх	шатны ажилтан, албан хаагчид химийн бодистой харьцах заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах	Төслийн хугацаанд	зардлаар тооцсон		зардалд тусгасан		бодисын тухай хууль
<b>Зардал</b>						<b>1950.0</b>		

## 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монцемент билдинг материалс -ийн “Сэнжит худаг” шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төсөл нь өөрийн үйл ажиллагаандаа ISO 45001 буюу Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна. Уурхай болон үйлдвэрийн гэнэтийн ослын эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг доорх хүснэгтэд хураангуй байдлаар үзүүлэв. Уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө зардлыг үйл ажиллагаа болон БОМТ-ний зардалд зайлшгүй тусгаж хэрэгжүүлэн ажилласнаар төслөөс үүсэх аюул ослоос үүдэлтэй эрсдэлийг бууруулах, зайлс хийх бүрэн боломжтой байна. Аюул ослоос үүсэх эрсдэл нөлөөллийн эрсдэлийн үнэлгээнд нарийн тусган оруулсан болно.

**Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
<b>Аадар бороо, үер</b>	Хажуугийн урсацаар хөрс эвдрэх, уруйн идэгдэлд өртөж болзошгүй газруудад мөр жим гаргахгүй байх талаас анхаарч, жалганы ойролцоо хог хаягдлын цэг, шатах тослох материалын агуулах, бохир усны нүх зэрэг барилга байгууламж байрлуулахгүй байхад анхаарч хяналт тавьж ажиллана.	Уурхайн бүсэд	Байнга	Зардал шаардахгүй	-	Тухай бүрд	Гамшгаас хамгаалах тухай, Хог хаягдлын тухай хууль
<b>Аянга, цахилгаан</b>	ШТС, үүрэн телефоны антенн зэрэг байгууламж, объектуудад байрлуулсан аянга зайлуулагчийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, бэлэн байдалд байлгах. -Цахилгаан цэнэгтэй орчноос аль болох зайдуу байх, цахилгаан цэнэгтэй тоног төхөөрөмжүүдийг унтраах, аянга цахилгаантай үед хэмжилт хийх болон цахилгаан цэнэг үүсгэх багаж төхөөрөмжтэй ажиллахаас зайлсхийх, аянга цахилгаантай үед утсан холбоо хэрэглэхгүй байх, шаардлагатай тохиолдолд цахилгаанаар ажилладаг бүх тоног төхөөрөмжийг унтраах	Уурхайн бүсэд МБМ ХХК	байнга	Зардал шаардахгүй	-	Тухай бүрд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
<b>Хүчтэй салхи, шуурга</b>	Хүчтэй салхины цаг агаарын шинэчилсэн мэдээллийг тогтмол сонсож уурхайн шуурхай хуралдаан дээр	Уурхайн бүсэд	байнга	-	-	Тухай бүрд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Аюулын үед

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	мэдээлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх.						хэрэгжүүлэх төлөвлөгөө
<b>Үйлдвэрлэлийн болзошгүй аюул, осол</b>	Ажилд хэрэглэгдэх уул тээврийн машин механизмын найдвартай ажиллагаа хангагдсан, тэдгээрийн сигнал, тоормос, хөдлөх эд ангиудын хаалт, гал унтраах хэрэгслүүд, гэрэлтүүлэг зэрэг бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж байх. -Уул тээврийн машин механизмуудын тосолгоо, арчилгааны материалуудыг битүү төмөр саванд хадгална.	ЗМХ, ХАБЭАБОХ ШТС, Агуулах	тухай бүр	Уурхайн үйл ажиллагааны зардал тусгагдсан. Зарим ажлууд зардал шаардахгүй зохион байгуулалтын ажил болно.	-	Тухай бүрд	Ашигт малтмалын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай
<b>Эрүүл мэндийг хамгаалах талаар</b>	Ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах.	Уурхайн нийт ажилчид	730	Үйл ажиллагааны зардалд тооцогдоно.	-	Тухай бүрд	Эрүүл мэндийн тухай хууль
<b>Ил уурхайн гарч болзошгүй осол</b>	Уурхайд гарсан осол, аюул, хор уршгийг шуурхай арилгах, даамжрахаас урьдчилан сэргийлэх, хүний амь насыг аврах төлөвлөгөө боловсруулан баталж ажиллах	Ил уурхай ба уурхайн бусад талбай	Жилд 1 удаа	1750.0	1750.0	2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль 24-25 дугаар зүйл Хүдрийн ил уурхайн аюулгүй байдлын дүрэм Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/75 дугаар тушаал (2016-03-25)
	Тэсэлгээний бодисын агуулахын хамгаалалтын далан шинэчлэх, камер суурилуулах, гэрэлтүүлэг шинэчлэх.	Уурхайн бусад талбай	1ш камер	Үйл ажиллагааны зардалд тооцогдоно.	Үйл ажиллагааны зардалд тооцогдоно.	2024 он	



Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
<b>Нийт дүн</b>					<b>1750.0</b>		

“Монцемент билдинг материалс” -ийн Сэнжит худаг шохойн чулуу, цахиурлаг занарын ордыг ил аргаар ашиглах, цемент үйлдвэрлэх төслийн осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 1 750 000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна.

## 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Монцемент Билдинг Материалс” ХХК –ийн бохир ус цэвэршүүлэх байгууламж нь цагт 10 м<sup>3</sup> бохир усыг цэвэрлэх хүчин чадалтай. Механик, биологийн болон гүний цэвэрлэгээ бүрэн хийж хлорын диоксидоор халдваргүйжүүлж үйлдвэрийн технологийн усанд эргүүлэн ашигладаг учир шингэн хаягдал үүсэхгүй. Харин уурхайн болон үйлдвэр ажилчдын хотхоноос ахуйн болон үйлдвэрээс ахуйн хуурай хог хаягдал гарахаар байна. Төслийн үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөллийг аль болох бага байлгах үүднээс хог хаягдлын менежментийг маш сайн хэрэгжүүлэх ажиллах шаардлагатай.

Зураг 2. Хог хаягдлыг бууруулах менежментийн үндсэн зарчим



Төслийн хүрээнд хог хаягдлыг менежментийг хэрэгжүүлэх зорилгоор дараах дотоод журмуудыг даган мөрддөг.

- Хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам
- Аюултай хог хаягдлыг цуглуулах хадгалах журам


Журмын дагуу доорх арга хэмжээг авч хэрэгжүүл ажиллана.

Үүнд:

- Уурхайн хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулах
- Хогийг анхан шатанд нь ангилан, ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлэх
- Зориулалтын хогийн савнуудыг тусгай талбайд байрлуулж, битүүмжлэл сайтай байлгах
- Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулах, ажилчдад заавар зөвлөмж өгөх

- Орон нутагт жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор уурхайн хог хаягдлыг тээвэрлэх, устгах зэрэг ажлуудыг гүйцэтгэх орон нутгийн компани, сумын удирдлагатай хамтарсан гэрээ байгуулан хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлэж байх
- Уурхайн машин механизмаас гарах тос, тосолгооны материалын сав хуванцарыг битүүлж сайтай боловсруулах үйлдвэрт тушаах
- Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх
- Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож зөв чиглүүлж өгдөг. Хог хаягдлын ангилан ялгалтыг эх үүсвэр дээр нь болон хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог хаягдлын ангилан ялгалтыг хялбар, үр дүнтэй байлгах зорилгоор хогийн савуудыг өнгөөр кодчилсон ба хог хаягдлын төрлөөр хаягжуулсан савнуудыг шаардлагатай цэгүүдэд байрлуулан ажилладаг байна.

**Зураг 3. Хог хаягдлын нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө**



**Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө**

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян/төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Ахуйн	10.1.1 Хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж, төлбөрийг гэрээний дагуу төлөх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Сард 1 удаа	137.5	12	2004.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль
	10.1.2 Хог хаягдлын бүртгэл хөтлөх.	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Өдөр бүр	ҮАЗ	-	ҮАЗ	2024 он	Хог хаягдлын тухай хууль
	10.1.3 Ахуйн хог хаягдлаас дахин боловсруулах, хог хаягдлыг аймгийн төвт “Дэлгэр Дэрс” ХХК гэрээ байгуулан нийлүүлэх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Сард 1 удаа	30.0	12	-	2024 он	Хог хаягдлын тухай хууль
	10.1.4 Дулааны улиралд хогийн сав, гал тогоо, ариун цэврийн байр, хогийн цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	м <sup>2</sup>	ҮАЗ	5800	-	2024 он	Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуй, халдвар хамгаалалын тухай хууль.
	10.1.5 Орчны хог хаягдалд тогтмол хяналт тавьж, сар тутам орчны цэвэрлэгээг хийнэ.	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Сард 2-3 удаа	ҮАЗ	-	-	2024 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль.
Үйлдвэрийн	10.2.1. Засварын газраас гарах ашигласан тос, нефть бүтээгдэхүүнийг цуглуулан, хадгалах, дахин ашиглан гэрээт компанид гэрээний дагуу нийлүүлэх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Жилд	-	1	-	2024 он	Хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль.

	10.2.1. Хог хаягдлыг БОХ-6.1, маягтын мэдээллэх	БОХ-6.2 дагуу	Үйлдвэр болон Сэнжит худаг, уурхай ажилчдын орон сууц	Жилд	-	1	-	2024 он	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
Аюултай	10.3.1. Аюултай хог хаягдал болох тос масло асгарсан тохиолдолд бүртгэл хөтөлж саармагжуулалтыг газар дээр нь авч ажиллах, хяналт тавих		Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Өдөр бүр ажлын байрны үзлэг шалгалт	ҮАЗ	-	-	2024 он	Хог хаягдлын тухай хууль
	10.3.2 Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан мэдээг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх		Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Жилд 1 удаа	ҮАЗ	1	-	2024 он	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
<b>Нийт</b>								<b>1650.0</b>	

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал нь дээрх хүснэгтэд тооцоолсноор жилд 1 650 000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

## 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар тухайн төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгчид өгөгдсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжүүлэгчээс байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүн, төслийг хэрэгжүүлж буй сумын нутаг дэвсгэрт бий болж болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор хяналтын үзүүлэлтүүд, байршил, хийх хугацаа, зардал, баримтлах стандарт, аргачлалыг тодорхойлж энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь төслийн нөлөөллийн болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг илтгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

БОХТ болон ОХШХ-ийн хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах.

**Хүснэгт 11. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр**


Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>1. АГААРЫН ЧАНАР</b>							
Тоосжилт (PM10, PSM, PM25); Бохирдлын цэгэн эх үүсвэр (SO2, NO2)	<b>Нийт 5 цэгт</b> Уурхайн карьер Технологийн зам Ууттай цемент ачих хэсэг Цемент задгайгаар савлах хэсэг Түүхий эдийн нэгдсэн агуулах	2024 он	1	33.0	231.0	Нэгж дээжний үнийг БО-ны төв лабораторийн 2023 оны үнээр тооцсон. Хэмжилтийг хийхдээ уурхай болон үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байх үед хийх илүү бодит үр дүн гарна.	MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага; MNS0017-2-3-16:1988 Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ; MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ; MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга; MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO2 тодорхойлох эзлэхүүний арга; MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга; MNS0012-1-015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга; MNS0017.2.5.12:8988. Хүхэрлэг хий-SO2 шинжлэх ТХМ буюу аэрозалины арга; MNS0017.2.5.11-1998. Азотын давхар исэл.
Гадны орчны дуу шуугиан			1	3.0	21.0		
Дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ - Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин)	Цементийн үйлвэрийн дотоод орчинд	2024 он	1	36.0	36.0		
<b>1 жилд</b>					<b>288.0</b>		
<b>2. ГАЗРЫН ДООРХ УС</b>							
Ca, Mg, Cl, SO4, NO2, NO3, NH4, HCO3, Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Саийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан	Уурхай болон үйлдвэрийн усны эх үүсвэр болох 5 гүний худгууд 5 дээж авч шинжлүүлнэ.	2024 он	1	80.0	400.0	Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн усны лабораторийн үнээр тооцов.	MNS 3900:1986 Ундны ус. Амт, үнэр, өнгө булингарыг тодорхойлох арга MNS ISO 7887:2000 Усны чанар. Өнгө тодорхойлох ба шалгах MNS 1097:1970 Гэр ахуй, ундны усны физик-химийн шинжилгээний арга

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
дамжуулах чанар, усны түвшин							MNS 1066:1985 Ундны ус. Эрүүл зүйн бактер судлалын шинжилгээний аргууд
Цэвэршүүлсэн усны бактерлогийн шинжилгээ	Цэвэршүүлэх байгууламжийн гаралтаас 1 цэг 1 дээж	2024 он	1	50.0	50.0	Баримжаа үнээр тооцов.	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 3935:1986 Ахуйн хэрэгцээ, ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
<b>1 жилд</b>					<b>450.0</b>		
<b>3. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>							
Хөрсний ялзмаг	Уурхай шимт хөрсний овоолго 1 цэгээс 2 дээж	2024 он	1	20.0	5.0	Дээжний үнийг Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн хөрс судлалын лабораторийн үнээр тооцов.	Хөрсний хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”,  Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль  MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
Урвалын орчин (рН), давсжилт, карбонат (CaCO <sub>3</sub> ), хөдөлгөөнт кали (K <sub>2</sub> O), хөдөлгөөнт фосфор (P <sub>2</sub> O <sub>5</sub> ), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин	Уурхай, үйлдвэрийн талбай, хогийн цэг гэх мэт 3 цэгийн 3 дээжинд		1	20.0	250.0		
Хөрсний хүнд металлын бохиролтыг хянах Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As) гэх мэт үзүүлэлтээр	Уурхай ШТС, үйлдвэр, авто засварын газар, хогийн цэг гэх мэт 3 цэгт		1	33.0	189.0		
<b>1 жилд</b>					<b>489.0</b>		



Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>4. УРГАМЛАН НӨМРӨГ</b>							
Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га Ургамлын үрийн банк Ургамлын нягтшил 1м²/бодгаль Тоосжилтын нөлөө	Уурхай, үйлдвэр, тосгоны талбай орчимд 5 цэгт, нөлөөлд өртөөгүй буюу харьцуулах хяналтын 2 цэгүүдэд	2024 он	1	Судлаачийн зардал	900.0	Зун ургамлын вегтацын идэвхитэй үед 7-8 сарын хооронд	“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”, Ургамлын бүрхэцийг Раменскийн тор ашиглан нүдэн баримжааны аргаар, арвийг Друде-ээн аргаар, биомасс ургацын хэмжээг жингийн аргаар тодорхойлно.
<b>1 жилд</b>					<b>900.0</b>		
<b>5. АМЬТНЫ АЙМАГ</b>							
Амьтны аймгийн мониторинг судалгаа, мониторингийн цэгүүд дээр тохиолдсон амьтадын төрөл зүйлүүдийг бүртгэх, байршлыг тодорхойлох, хамгаалах арга хэмжээний зөвлөмж боловсруулах	Төслийн талбайн ойр орчимд	2024 он	1	Судлаачийн зардал	900.0	Зуны улиралд нэг удаа	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль  “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”,
<b>1 жилд</b>					<b>900.0</b>		
<b>Нийт орчны хяналт шинжилгээний зардал</b>					<b>3087.0</b>		

Зураг 5. Төслийн талбайн мониторингийн цэгүүдийн байршил



## 12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Төсөв (мян.төг)	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцагч	Баримтлах хууль журам, стандарт
			2024 он				
			4 сар	5 - 7 сар	8 - 11 сар		
1.	Монцемент үйлдвэр болон уурхайн үйл ажиллагаа явуулахад шаардагдах төлөвлөгөө, гэрээ, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн ажиллана.	-	+	+	+	Байгаль орчны мэргэжилтэн	“Байгаль хамгаалах тухай” хууль БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29 А-618 тоот тушаал; -
2.	Хаягдал усны дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл сунгах	200.0	-	+	-	Байгаль орчны алба	
3.	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд: Экологийн боловсрол, мэдлэг, мэдээлэлийг олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулж ажиллах	500.0	-	+	-	Байгаль орчны мэргэжилтэн	
4.	Байгаль орчны Аудитын тайлан хийлгэх	ҮАЗ	+	-	-	Байгаль орчны мэргэжилтэн	
<b>Нийт төсөв</b>		<b>700.0</b>					

### 13. БОМТ-ӨӨГ СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын ямаар батлуулан цахим системд байршуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.

*Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Зардал, мян.төг
Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	БОМТөлөвлөгөө болон биелэлтийн тайланг байгаль орчны цахим мэдээллийн системд тогтсон хугацаанд байршуулах	2024 он	БОМТ-д тусгах	БОАЖГ	-
Дорноговь аймгийн Өргөн сум ЗД болон байгаль орчны мэргэжилтэн	БОМТөлөвлөгөө болон биелэлтийн тайлангийн талаар уулзалт хийх мэдээлэл солилцох	2024 он	БОМТ-д тусгах	Монцемент Билдинг Материалс ХХК	-
Өргөн сумын 4 баг	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хийгдэж буй ажлын талаар танилцуулах	2024	БОМТ-д тусгах	Монцемент Билдинг Материалс ХХК	-
<b>Нийт</b>					<b>500.0</b>

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэхэд 500 000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төслийн Техник эдийн засгийн үндэслэл
2. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээний дүгнэлт
3. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээний тайлан
4. Төслийн 2024 оны уулын ажлын төлөвлөгөө
5. 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А-618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
6. Байгаль орчин ногоон хөгжлийн яамны вэб сайт –[www.met.gov.mn](http://www.met.gov.mn)
7. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны вэб сайт – [www.energy.gov.mn](http://www.energy.gov.mn)
8. Ашигт малтмалын газрын вэб сайт – [www.mrpam.gov.mn](http://www.mrpam.gov.mn)
9. Эрхзүйн мэдээллийн сайт – [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
10. Дорноговь аймгийн вэб сайт – [www.dga-boajg.bblog.mn](http://www.dga-boajg.bblog.mn)

## **ХАВСРАЛТУУД**

**Хавсралт 1.** Улсын бүртгэлийн гэрчилгээ

**Хавсралт 2.** Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл

**Хавсралт 3.** БОМТөлөвлөгөөний зураг

**Хавсралт 4.** Хяналтын хуудас

**Хавсралт 5.** Байгаль орчны барьцаа хөрөнгөний хуулбар

**Хавсралт 6.** Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил